



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Барилга, хот байгуулалтын яам

Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Инженерийн дэд бүтцийн хэлтэс /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14 ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Дэс түшмэл, ТЗ-8 /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Барилга байгууламжийн цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын бодлого, хууль, эрх зүйн орчинг боловсруулж болгох санал боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

<p>1.Барилга байгууламжийн цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын хууль, эрх зүйн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох санал боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</p> <p>2.Барилга байгууламжийн цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын чиглэлээрх норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, батлуулах ажлыг зохион байгуулах, зохицуулах;</p> <p>3.Барилга байгууламжийн цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын шугам сүлжээний ажлын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих;</p> <p>4.Хууль тогтоомжоор олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p>			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход салбарын чиглэлээрх төрөөс баримтлах бодлогын баримт бичигт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;	Хууль, эрх зүйн орчин боловсронгуй болж, санал өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байх.	Т, Г, Х
	2.Салбарын цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын шугам сүлжээний чиглэлээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тооцоо судалгааг холбогдох эрх зүйн баримт бичигтэй уялдуулан боловсруулах, нийгэм, эдийн засгийн үндэслэл, статистик тоон баримт, мэдээ, мэдээлэлд тулгуурлан боловсруулах;	Инженерийн дэд бүтцийн салбарын хууль, эрх зүйн орчин сайжирч, салбарыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл хэрэгжсэн байна.	Т, Г
	3.Салбарын хууль, тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд эрчим хүч, цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын системийн чиглэлээр санал өгөх;	Хуульд нийцүүлэн боловсруулж, мөрдлөг болгосон байна, инженерийн дэд бүтцийн салбарын хууль, эрх зүйн орчин сайжирсан байна.	Т, Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын системийн чиглэлээр норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох, норм, нормативын сангийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулах;	Салбарын норм, нормативын баримт бичгийн чанар, хүртээмж сайжирсан байна.	Т, Г
	2.Хариуцсан ажлын чиглэлээр эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдээс шинэчлэх, өөрчлөх, нэмэлт оруулах норм, дүрэм, журам, стандартын судалгаа гаргах, төлөвлөх үе шат, хугацааг тодорхойлох, норм, стандартыг	Хуульд нийцүүлэн боловсруулж, мөрдлөг болгосон байна, инженерийн дэд бүтцийн салбарын хууль, эрх зүйн орчин сайжирсан байна.	Т, Г, Х



	боловсронгуй болгоход санал өгөх, батлуулах;		
	3.Шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах чиглэлээр санал боловсруулах;	Салбарт шинэ техник, технологи нэвтэрч үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах нөхцөл бүрдэнэ	Т, Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Салбарын цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын шугам сүлжээний чиглэлээрх ажлуудын саналыг авч нэгтгэх, төлөвлөх, санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар шийдвэрлүүлэх санал боловсруулах;	Салбарын байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Г, Х
	2.Салбарын цахилгаан хангамж, автоматжуулалт, холбоо дохиоллын шугам сүлжээний чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах;	Холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна.	Т, Г, Х
	3.Аймаг, нийслэлийн цахилгаан хангамж, холбоо дохиолол, автоматжуулалтын шугам сүлжээний барилга байгууламжийн бодлого, төлөвлөлт, техникийн шийдэл гаргах, ажлын уялдаа холбоог сайжруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;	Салбарын хэмжээнд улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн, хяналт тавьж, зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна.	Т, Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;	Хууль тогтоомжид заасан ёс зүйн холбогдох заалтыг чанд мөрдөж ажилласан байна. Ёс зүйн болон бусад төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн байна.	Г
	2.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;	Өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэсэн байна.	Г
	3.Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.	Мэдээллээр хангаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн байна.	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол

- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.



Мэргэжил	- Цахилгаан хангамж /071305/; - яамны үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны чиглэлийн мэргэжлийн инженер.	
Мэргэшил	- Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/	
Туршлага	- Яамны мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч тэдгээртэй адилтгах албан тушаалд ажилласан бол давуу тал болно. /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх; - асуудлын шийдэлд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байж, бусдыг дэмжих; - шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг нэвтрүүлэх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн технологи ашиглах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - жендерийн эрх тэгш байдлыг хангах; - авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:


- Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга


Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- УИХ, ЗГ-ын харьяа төрийн захиргааны байгууллагууд;
- Яам, агентлаг, нутгийн захиргааны болон бусад төрийн байгууллагууд;
- Төрийн бус байгууллагууд;
- Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд;
- Иргэн, хуулийн этгээд.



V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  Д. БАЯРСАЙХАН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2020 оны 10 дугаар сарын 14 -ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 20 10 14 Дугаар: 340

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:	
Байгууллагын нэр: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ	
Шийдвэрийн огноо: 2020 оны дугаар сарын -ны өдөр	
Дугаар:	
(тамга/тэмдэг)	
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА нэр)	 С.МАГНАЙСҮРЭН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)
2020 оны 10 дугаар сарын 16 -ны өдөр	

